




5th Story

УСЫГ ДАРС БОЛГОСОН НЬ

Water to Wine

Усыг дарс болгосон нь!

– 5th Story –



Зарц За за чишш ... нэг нууц хэлж өгье. Сая миний харсан зүйлд итгэхэд бэрх байж магадгүй. Бид хуримын үдэшлэг хийж байсан юм. Би найзуудтайгаа зүгээр л энд ажиллаж байсан. Үнэндээ бол би энд ирсэн хүмүүсийг сайн мэдэхгүй. Харин үдэшлэг ид өрнөж байхад бүр гайхалтай зүйл болсон.

Зарц 1 сайн уу~ хөөх~~ дарсыг ч асгартал ууж байх чинь? Нэг торх тэр дорхноо л дуусаж байна?

Зарц 2 Хэр зэрэг үлдсэн бэ?

Зарц 1 Энд ганцхан торх л байна?

Зарц нар Ганцхан? Нээрээ юу? Хаанаа ч хүрэхгүй дээ ~ удахгүй үүр цайх нь, яах вэ?

Зарц 1 харин тиймээ ... нэг тийшээ очиж арга хайх хэрэгтэй.

Зарц 2 Хэн нэгэн туслах хүн байвал сайнсан.

Зарц тийм юм болсон. Үдэшлэг яг ид өрнөж байхад дарс аль хэдийнээ дуусаад, ямар их сандарсан гээч? Олигтойхон бэлдсэнгүй гэж биднийг загнах учраас том хэрэг мандсан шүү? Тэгээд би туслах хүн хайж ийш тийш явтал гал тогооноос нэг эгчийг олсон. Нэрийг нь Мариа гэж хэлсэн. Хөөе ~~ би хэнд хэлэхээ сайн мэдэхгүй байна ... бидэнд нэг асуудал гараад байна аа.

Мариа ямар асуудал гараа вэ?

Зарц Мм .. дарс удахгүй дуусах нь. Бараг бүгдийг нь уучихсан.

Мариа Юу гэнээ? Яахлаараа ийм явдал болдог байна аа?

Зарц Хүмүүс үнэхээр их ирсэн шүү дээ. Тэгээд уур амьсгал ч сайхан болж, бүгд л хөгжилдөн ууцгаасан. Яах вэ? Сүйт бүсгүй үнэхээр уурлах байх даа ...

Мариа Санаа бүү зов. Тусалж чадах нэг хүн байна ... харин намайг Мариа гэдэг.

Зарц Сайнаар шийдэгдээсэй. Ямартай ч уулзсандаа баяртай байна.

Мариа Есүс ээ, надад тусалж чадах уу?

Есүс Мэдээж. Яаж туслах вэ?

Мариа Энд ажилладаг хүмүүс ирээд дарс дуусчихлаа гэнээ, туслах ямар арга байна вэ?



Есүс	Мм... эгч ээ, яагаад надад ийм зүйлийг хэлнэ вэ? Миний цаг хараахан болоогүй байхад, эгч та ч гэсэн сайн мэдэж байгаа шүү дээ.
Мариа	Есүс ээ, би ч гэсэн мэдэж байна. Гэхдээ чиний хийж чадах зүйл байвал юунд ч тус дэм болно. Тусалж чадах уу?
Есүс	Ойлголоо
Мариа	Баярлалаа, за энд байна. Та хоёр нааш ир. Түүний хий гэсний дагуу хийхэд болно, ойлгов уу?
Зарц нар	аа... за ойлголоо
Есүс	За, тэр ард 6 ш усны сав харагдаж байна уу?
Зарц нар	Тийм байна ... гэхдээ ...
Есүс	Нэг саванд 75 литр ордог. Одоо та хоёр очоод усаар пиг дүүргээрэй.
Зарц 1	байзаарай, нэг асуулт байна. Яагаад бид усаар дүүргэх ёстой билээ? Бид чинь дарс олж ирэх ёстой биш билүү?
Есүс	Миний хэлснээр хийгээрэй. Дарсанд бүү санаа зов. Мэдэж байна аа. Бүү санаа зов. Миний хэлснийг бүгдийг ойлгосон биз дээ?
Зарц нар	За, тэрийг ч хийж чадна аа.
Есүс	хурдлаарай. Дарс удахгүй дууслаа.
Зарц 2	гэхдээ
Зарц	яахав дээ? Бид зүгээр л тэр Есүс гэдэг хүний хэлснээр хийсэн. Одоо дарс дуусаад бөөн юм болж байгаа, яагаад бид тэр том усны савыг усаар дүүргэх ёстойг, бас дүүргэхэд ямар их цаг зарцуулна гээч, тэгээд үргэлжлүүлээд хийгээд байх уу, огтхон ч ойлгохгүй боловч зүгээр л хийсэн.
Зарц 2	Тэр Есүсийг галзуурсан гэж бодсон. Мариа эгч, Есүс хоёр хоёулаа галзуураад бүгдийг сүйтгэнэ гэж хүртэл бодсон юм чинь.
Зарц 1	Үнэхээр тэгнэ гэж бодсон. Би ч гэсэн
Зарц 2	Мм.. би юу ч бодолгүй ус л дүүргэсэн. Харин тэр хоёр биднийг мэхэлсэн байж ч магадгүй гэж бодсон.
Найрын хариуцагч	Байз ... хүмүүс ээ. Дахиад дарс уумаар байна уу?(тэгье, тэгье) за за чи яваад дарсаа бүгдийг аваад ир.
Зарц	Өө .. аа .. за .. ойлголоо.
Есүс	бүү санаа зов. Надтай хамт яв.
Зарц нар	Есүс ээ, бид бүгдийг дүүргэх нь дүүргэсэн.
Есүс	сайн байна. Маш сайн байлаа. За одоо тэр усны савнуудыг аваачиж өгөөрэй.
Зарц 2	хар л даа, би хэлээгүй юу? Тэр биднийг мэхэлж байна гэж ... би лав хийхгүй, энэ чинь зүгээр ус шүү дээ, галзуураа юу?

Есүс Хэн явах уу?

Зарц 1 Би хийе ээ.

Эзээн, энд байна.

Найрын зочин Мм за, энэ үнэхээр амттай юм байна? Үдэшлэгт би олон очиж үзсэн. Эхлээд сайн дарс гаргаж тавиад хүмүүс согтохоор муу дарсаа гаргадаг. Гэтэл энд шал эсрэгээрээ. Жинхэнэ сайн дарсаа нууж байсан байх нь ...

Сүйт залуу өө, аа ... заза, хэ хэ

Зарц нар Пөөх яаж? Яаж ийм явдал?

Мариа Есүс ээ, баярлалаа

Зарц тиймээ, зөв. Энэ Есүс байсан. Усны саваар дүүрсэн усыг дарс болгосон. Тэгээд бүр хамгийн сайн дээд зэрэглэлийн дарс болгосон. Бүгд тэгэж хэлцгээсэн. Түүнд ямар нэг асар их хүч байгаа юм шиг санагдсан.

